

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга* 0

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-11

- 
1. *Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 4-9
2. *Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 9-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 02-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 11 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Бейсен, С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Саранчимэг, Ц.Туваан;

Чөлөөтэй: Б.Баярсайхан, Х.Булгантуяа.

**Нэг.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төрийн цэргийн байгууллагын асуудал хариуцсан ахлах референт Т.Буянбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хийв.

**П.Анужин:** Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсайхан, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 31 минут үргэлжилж, 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж 52.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 42 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 11 минут

**НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**П.Анужин:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52,9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя. Жаргалмаа гишүүн хүрэлцэн ирсэн байна. Оюунчимэг гишүүн ирсэн байна. Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Сарангэрэл гишүүн ирсэн байна. Одонтуяа гишүүн ирсэн байна. Чинбүрэн гишүүн ирсэн. Чинзориг сайд ирсэн. Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхээс 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, энэхүү хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Түүний дараа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Энэхүү хуулийг Монгол Улсын Засгийн газраас

2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр яаралтай горимоор өргөн мэдүүлсэн байгаа/. Энэхүү хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэх юм.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг үг хэлнэ. Мөн Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ ээ. Содномын Чинзориг сайд үг хэлье.

**С.Чинзориг:** Байнгын хорооны дарга аа, энэ хэлэлцэх асуудал дээр ажлын хэсэг байгуулах тухай санал оруулаад, ажлын хэсгээ байгуулчихвал яасан юм. Эм, эмнэлгийн хэрэгслийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр ажиллах, анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгээ өнөөдөр бас байгуулаад явчихгүй бол аягүй бол ирэх 7 хоногт чинь дахиад бас хуралдах гээд бас нэлээн цаг алдана шүү дээ. Тэгэхээр өнөөдөр энэ ажлын хэсгээ байгуулаад, тэгээд ажлын хэсгээ ажилд оруулчих асуудлыг давхар яриад явчихвал гэсэн ийм саналтай байна.

**П.Анужин:** Чинзориг сайдын хэлж байгаа санал маш чухал санал. Дэггүй байсан бол тэгмээр байна. Тэгээд Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиараа хэлэлцэх эсэхийг Байнгын хороо дэмжсэний дараа заавал Улсын Их Хуралд чуулганаар өргөн мэдүүлж байж чуулганаар хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа ажлын хэсэг байгуулна. Тийм учраас энэ саналыг дэмжих боломжгүй байна. Ер нь бол зарчмын хувьд зөв юм байгаа юм. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлье.

**М.Оюунчимэг:** Би энэ иргэдтэйгээ уулзаж байхад маш олон ээжүүд 4 ба 5, түүнээс дээш хүүхэд төрүүлсэн ч гэсэн явцын дунд нэг нь эндсэн ийм тохиолдолд нөгөө алдарт эхийн одон өгдөггүй, бас тэрэнтэй холбоотой асуудлууд байдаггүй. Тэгээд маш олон ээжүүд энэ асуудлыг шийдэж өгөөч ээ гэсэн байсан. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч энэ

хуулийн төслийг санаачилж байгаа гэсэн. Энэ цэргийн хуультай хамт оруулаад ирэх бололцоо байгаагүй юм болов уу. Уг нь тэр байсан бол шуурхай хэлэлцчихвэл маш олон ээжүүд тэгээд байдаг байхгүй юу хөөрхий. Амьдралын дунд 1, 2 нь эндчихсэн хэрнээ Алдарт эхийн одон авч чаддаггүй, уг нь бол 4, 5, 6 хүүхэд төрүүлчихсэн байгаад байдаг. Тэгээд Ерөнхийлөгч санаачилж байгаа гэж би сонссон. Тэгээд энэ асуудал хаана, яаж байгаа юм бол. Содбаатар даргаас би тодруулах гэсэн юм болох уу.

**П.Анужин:** Их чухал асуудал асууж байна. Бид нар бас энэ дээр хариулт авах нь зөв. Хэлэлцэх асуудлынхаа эхний асуудалд оръё.

**Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхээс 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хийе.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар танилцуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд урьж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэндээ танилцуулъя. Янугийн Содбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Рагчаагийн Батрагчаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх, Дашицэдэнгийн Баасандамба Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал, Хожгорын Лхагвасүрэн Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, хошууч генерал, Гомбожавын Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал, Төмөрмөнхийн Буянбат Монгол Улсын

Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төрийн цэргийн байгууллагын асуудал хариуцсан ахлах референт. Ийм бүрэлдэхүүнтэй хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар танилцуулна.

**Я.Содбаатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ. Мөн зүйлийн 1 дүгээр хэсгийн 5-д өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөн тусламж авах эрхтэй. 19 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасан байдаг.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зэвсэгт хүчин, хил ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч. Энэ хуульд цаашид цэргийн албан хаагч гэж байгаа сонсогч нар тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбоотой олон салбарын албан хаагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалтай холбогдох харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн эдгээр албан хаагчдын нийгмийн хамгаалал эрх зүйн байдалтай холбогдох харилцааг салбарын хуулиудаар тусгайлан зохицуулсан бас байдаг. Тухайлбал Гамигаас хамгаалах



тухай хуулиар онцгой байдлын байгууллагын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн албан хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүнийг гэр бүлд 1 удаа олгоно.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 38.4-д иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт хэргийн халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн буцалтгүй тусламж олгоно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86.1-д цагдаагийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн албан хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд 1 удаа олгоно гэж ялгамжтай тогтоосон байна.

Иймд Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлд Цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоох, авах нөхцөл шалтгааныг зааж өгсөн бөгөөд салбарын бусад хуультай уялдуулан цэргийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагад өртсөн, гэмт хэргийг таслан зогсоох, онц байдлын үед хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авах эрхийг нэмж тусгах, түүнчлэн онцгой гавьяа байгуулан нас барсан цэргийн албан хаагчийн ар гэрт олгох тэтгэвэр, тэтгэмжийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд цэргийн албан хаагч өөрийн амь насыг эрсдэлд орохыг мэдсээр байж эр зориг, мэргэжлийн ур

чадвар гарган төр, нийгэм, олон нийтийн аюулгүй байдалд учирч бол хохирлыг таслан зогсоосон. Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалсны улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүний тооноос үл хамааран 100 хувиар тогтоох. Түүнчлэн тухайн цэргийн албан хаагчийн гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 400 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний 1 удаагийн тэтгэмж олгох асуудлуудыг тусгалаа.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод болон орон нутагт 3 өрөө орон сууцын талбайн хэмжээ нь 60м<sup>2</sup>-аас 150м<sup>2</sup> хүртэл байх бөгөөд түүнчлэн Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор баталсан Орон сууцын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журмын 2 дугаар зүйлийн 2.1.4-д нийт талбайн хэмжээ нь 80м<sup>2</sup>-аас ихгүй байхаар зохицуулсан байх тул 3 өрөө орон сууцын талбайн хэмжээг 80м<sup>2</sup> байхаар тооцож хуульд тусгалаа. Шинэ орон сууцын 1м<sup>2</sup> талбайн дундаж үнэ нь 2 сая 65 мянгаас 3 сая 99 мянган төгрөг байх бөгөөд дунджаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тооцож хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлуудыг хүлээн авч төсөлд бас тусгалаа.

Түүнчлэн хуулийн төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсанд байршуулан иргэн олон нийтийн саналыг авсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын албан хаагчдын гэр бүлд олгох тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэж, нийгмийн баталгаа

сайжирч, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**П.Анужин:** Содбаатар даргад баярлалаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Асуулт, үг хамт явна гишүүд ээ. Улсын Их Хурлын чуулганы завсраар бид нар яаралтай өргөн баригдсан хуулийг хэлэлцэж байгаа учраа. Нэрсийг авъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр нэрсийг тасалъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**М.Оюунчимэг:** Том утгаар нь агуулгын хувьд дэмжиж байна. Мэдээж энэ бол чухал асуудал. Харин сая хэлж байгаа энэ гэр бүлийн гишүүнд олгох тэжээгчээ алдсаны тэтгэврийн хөдөлмөрийн чадваргүй чадваргүй гишүүний тооноос үл хамааран 100 хувиар тогтооно. 400, 500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тусгана гэдэг бол нэлээд том хэмжээний санхүүжилтийн асуудал бас яригдах байх. Тэгэхээр одоо бол 2024 оны төсөв батлагдчихсан байгаа. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2025 оноос эхэлж хэрэгжүүлнэ гэж байгаа юм уу. Энэ санхүүжилтийг бол яаж тусгах вэ. Улсын төсөвт тусгахад хэдий хэмжээний хөрөнгө мөнгө орно гээд энэ дээр Сангийн яамны байр суурь ямар байгаа бол. Нэгд энд хариулт авахыг хүсэж байна.

2-т нь би түрүүн бас асуусан. Нөгөө 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн хэр нь нэг хүүхэд нь эндсэн ч юм уу тохиолдолд Алдарт эхийн одон авч чаддаггүй, үүнээс болоод олон мянган ээжүүд бас сэтгэл санааны, гэр бүлээрээ хүмүүс бас хүндхэн байдаг юм байна лээ. Тэгээд энэ асуудлыг шийдэж зохицуулж өгөөч. Төрүүлсэн нь үнэн гээд бид нартай уулзах болгондоо ярьдаг. Тэгээд эмэгтэй гишүүд энийг бол нэлээд их хөндөж тавьж байгаа. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч энийг бас санаачилж байгаа

гэсэн. Энэ хуулийн төсөл хэзээ өргөн баригдах юм бол. Энийг бас энэтэй уг нь хамтатгаад хэлэлцчихвэл цаг хугацааны хувьд их чухал санагдаж байна л даа. Энэ дээр би Содбаатар даргаас товч хариулт авахыг хүсэж байна. Баярлалаа.

**П.Анужин:** 2 дахь асуудал бол маш чухал асуудал. Үнэхээр Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд бол энэ асуудлыг үе үе тавьсаар ирсэн. Тэгэхдээ яг хуулийн зохицуулалт бол бүр түрүүлсэн байтугай 1 нас хүргэж байж өгдөг бүр ийм хатуу заалттай байдаг. Төрүүлсэн 4 хүүхэд байна. Гэтэл бүр 1 нас хүргэж байгаад өгдөг ийм хатуу үйлчлэлтэй шүү дээ. Тэгэхээр энийг бас хөндсөн нь Оюунчимэг гишүүн маш зөв асуудал хөндлөө. Асуултад харуул хариулъя. Янгугийн Содбаатар дарга хариулт өгье.

**Я.Содбаатар:** Оюунчимэг гишүүний 2 асуултад хариулъя. 1 дүгээрт бол бид нар өнөөдрийн яг мөрдөгдөж байгаа хуулиар бол тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээг бол хөдөлмөрийн чадваргүй нас барсны дараа түүний авч байсан сарын дундаж цалин хөлснөөс доор дурдсан хувиар тооцож тэжээгчээ алдсаны тэтгэврийг өгч байгаа юм. Өнөөдрийн хуулиар 1 ёсны хөдөлмөрийн чадваргүй 1 хүн үлдсэн бол 50 хувиар нь, хөдөлмөрийн чадваргүй 2 хүнд бол 75 хувиар нь, хөдөлмөрийн чадваргүй 3 түүнээс дээш бол 100 хувиар нь ингэж олгож байгаа юм. Тэгээд бид нар энэ удаа бол онцгой тохиолдолд амь насаа эрсдэж, өөрөө амь насаа эрсдэхээ мэдэж байж олон нийтийн төлөө, нийгмийн төлөө ингээд амь насаа алдсан бол 100 хувь тооцдог, 1 ёсны хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн дотор бол хүүхдүүд нь ордог. Дээрээс нь нөгөө гэрт байгаа хараа хяналтгүй хөдөлмөрийн чадвараа алдсан янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй ч гэдэг юм уу ийм хүмүүс ордог. Хуулийн заалтаар. Тэгэхээр 1 ёсны ерөнхийд нь өөрөөр хэлбэл 1 хүүхэдтэй байсан ч, 3 хүүхэдтэй байсан ч сүүлийнх нь хүүхдийг 18 нас хүртэл нь л бид нар

энэ хөдөлмөрийн цалинг нь тэр хүнд 10 хувиар тооцож цалинг нь олгоно л гэсэн үг. Ер нь бол энэ төрийн цэргийн байгууллагад ажиллаад, хилийн цэрэг, онцгой, цагдаа, батлан хамгаалах салбар, шүүхийн шийдвэр эд нарт явж байгаад үүргээ гүйцэтгэж байгаад, яг албан үүргээ гүйцэтгээд онцгой тохиолдол гарсан тохиолдолд нас барсан тохиолдолд 3 зүйл өгч байна л гэсэн үг. Үгүй ээ, тэр хөдөлмөрийн чадвар хүүхдээр нь тооцоход бол хүүхэд нь 18 нас хүрээд өөрөө хөдөлмөрийн чадвартай болно шүү дээ. Тэр хүртэл нь цалинг нь өгнө л гэсэн үг байхгүй юу. 1 дүгээрт ийм цалин өгдгийг 100 хувь болгож байгаа юм. 2 дугаарт бол орон сууцын дэмжлэг өгүүлэхээр орж ирж байгаа. Таны хэлдэг түрүүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин үржүүлсэн буюу өнөөдрийн ханшаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 мянга байгаа. Түүнийг 500 дахин үржүүлэхээр 330 сая төгрөг гэсэн үг байхгүй юу. Хэрвээ тэр айл 330 сая авъя гэвэл бэлнээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцоод өгчих, орон сууц авъя гэвэл 80м<sup>2</sup> орон сууц өгье л гэж байгаа юм. Тэгэхээр мөнгөө авах айл байдаг юм байна. Мөнгөө авна гэвэл мөнгө өгнө. Энийг нь төсөв дээр суулгаад явж байгаа. Тэгээд одоо энэ гарсан юун дээр хууль бол эргэж үйлчлэхгүй шүү дээ. Ийм тохиолдол гарвал Засгийн нөөцөөс гараад явчихна. Тийм учраас Засгийн газар дээр Сангийн яам нь дэмжсэн саналаа өгөөд явчихсан байж байгаа.

2 дахь асуудал бол энэ олон хүүхэд төрүүлж өсгөсөн хуульд бид нар энэ нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг Ерөнхийлөгч санаачлаад, Засгийн газраас саналаа авсан. Энийг бол ирэх 7 хоногийн эхэнд Их Хуралд өргөн барьчихна. Тэгээд би энэ хаврын чуулганд харин манай Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийг баталж өгөөсэй гэж бодож байгаа юм.

Тэгэхдээ амьдрал их баян юм байна. Энэ хуулийг үйлчлэл дотор тухайлбал хүүхдээ төрүүлчхээд, хүүхдээ

аваачаад хүнд үрчлүүлчихдэг тэр.../минут дуусав/

**П.Анужин:** Содбаатар даргад 1 минут нэмж өгье.

**Я.Содбаатар:** Тэгээд энэ өөрөө хуулийн нарийн зохицуулалт нь бас их чухал юм байна лээ. Зарим эцэг эхчүүд өөрсдөө эцэг эхийнхээ хариуцлагыг алдаад хүнд үрчлүүлчихдэг, бүр хаяад явчихдаг, асрамжид аваачаад өгчихдөг, маш олон ийм тохиолдлууд байдаг учраас бид нар яг хуулийн юуг нь харж байгаад эрсэдсэн, тэгэхдээ онцгой нөхцөлд осол аваар, үүгээр эрсэдсэн гэх юунуудыг нь заалтыг нь аваад хэлэлцүүлэг хийгээд, тэгээд ингээд хуулийн төслийг нь бол өргөн барьж байгаа энэ хаврын чуулганд баталж өгөх байх гэж бодож байна. Энэ бас нэлээн олон эхчүүдийн эмзэглэж хүлээж авдаг зүйл юм байна лээ. Тийм учраас энэ төрөөс олгодог одон, одонтой ээж болоод энийг аваад ирэхээр аяндаа дагаад нөгөө бас сар болгоны тэтгэмж жил болгоны нөгөө тэтгэвэр хураамж эд нарт нь оролцоод тэтгэлэг аваад явчихдаг. Мөнгөн дэмжлэг аваад явчихдаг ийм болох юм байна лээ.

**П.Анужин:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхийлөгчийн зүгээс өргөн барьж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Надад харин бас энэ цэргийн албаныхантай холбоотой бас нэг тодруулах ганц нэг зүйлүүд байгаа юм. Ер нь аймгийн Засаг дарга бол Хил хамгаалах туслах зөвлөлийн даргаар ажилладаг. Тэгээд хилийн анги салбарууд, застав дээр ажиллаж байгаа энгийн алба хаагчдын асуудал бас яригддаг. Миний ойлгож байгаагаар бол энэ Засгийн газраас явуулж байгаа хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд энэ цалингийн шатлалууд орон нутаг руу явах тусмаа л өндөрсөөд ингээд явж байгаа. Тэгэхээр яг хилийн отряд дээр, застав дээр нөхрөө дагаад, ар гэрээ



дагаад ажиллаж байгаа тэр энгийн албан хаагчдын цалин одоо сая энэ нөгөө төрийн албаныхны цалин хот, хөдөө гэж ингээж ялгамжтай нэмэгдэж байгаа энэ нэмэгдэлд ер нь хамрагдаж чадсан уу, үгүй юү. Сая бид бас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Онгон сумын хилийн дугаар ангиудаар бас явж алба хаагчидтай бас уулзсан. Хилийн нөхцөл байдал цалин хөлсний асуудал бол нэлээн сайн шийдэгдсэн ийм байдалтай байдаг юм байна лээ. Харин орон тоон дээр ажиллаж байгаа энгийн алба хаагчдын асуудал ер нь ямар ангилалд явдаг юм, яаж нэмэгдсэн бэ. Ялангуяа бол төрийн үйлчилгээ гээд энэ чинь урьд нь бол огт нэмэгдэж байгаагүй, ер нь л хаягдчихаад байдаг байсан. Сургуулийн жижүүр, манаач, Тамгын газрын жижүүрийн манаач гээд энэ хүмүүсийн асуудал бол шийдэгдсэнтэй адил энэ хилийн цэргийн ангийн алба хашиж байгаа тэр тогооч, үйлчлэгч, цэвэрлэгч гээд тэр хүмүүсийн цалин бас нэмэгдлээр жоохон тааруу байгаа юм уу даа гэж би ингээж ойлгосон. Тэр талаар бас нэг тодруулга авчихъя гэж бодож байна.

**П.Анужин:** 3 номерын микрофонд хариулт өгье. 3 номерын микрофоныг нээж өгье. Та битгий дараарай битгий. Микрофондоо битгий хүрээрэй.

**Х.Лхагвасүрэн:** Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, хошууч генерал Лхагвасүрэн. Эрхэм гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр сая тэр орон нутгийн нэмэгдэлд бол хамрагдаагүй юм. Энд болохоор орон нутгийн байгууллагууд буюу тэнд байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд эд нарын энгийн ажилчид бол хамрагдаад орон нутагт байгаа төрийн цэргийн байгууллагуудынх бол ороогүй явчихсан. Тэгээд бид нар ямар арга хэмжээ авч байна гэхээр ерөөсөө энэ цэргийн анги байгууллагад ажиллаж байгаа энгийн хүмүүс цэргийн дүрмээр ажиллаад, цэргийн хөдөлмөр хийгээд байдаг нь бол бас их хүнд юм. Тэгээд тэнд байгаа тогооч, энгийн тогооч гэхэд л өглөө,

өдөр шөнөгүй л ингээд л ажиллаад байгаа. Үйлчлэгч нь ялгаа байхгүй яг л цэргийнхэнтэй дагаж ажиллаад байгаа учраас нэг талаасаа цэргийн байгууллагад энгийн хүмүүс ажиллах юм бол тэр цэргийн цолтой байя эсвэл гэрээт цэргийн албан хаагч байя гэсэн нэг ийм санал дэвшүүлээд зарчмын хувьд сайдын түвшинд шийдээд хилийн заставд ажиллаж байгаа энгийн эмэгтэйчүүдийг гэрээт ахлагч гэсэн орон тоон дээр аваад тэр нь яах вэ гэхээр цэргийн албан хаагчийн нэгэн адил нийгмийн хамгааллын бүхий л цалин пүнлүү, нэмэгдлүүдийг авна, урамшууллыг авна л гэсэн ийм зарчимтай л явж байгаа юм.

**П.Анужин:** Идэрбат гишүүн тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Тийм байна лээ. Би бас авч л байгаа л гэж ойлголттой явж байсан. Тэгээд яг тэнд ажиллаж байгаа энгийн албан хаагч нар ихэнх нь бас ар гэрээ дагаад, нөхрөө дагаад дээд боловсролтой ч гэсэн тэнд тэгээд тогооч хийгээд явж байгаа олон хүмүүс байдаг юм байна лээ. Тэгээд тэр хүмүүс өнөөдөр ингээд 4 сарын цалин буугаад төрийн үйлчилгээний алба хаагчдын цалин орон нутагт бол ингээд 1 сая 200, 300 болтлоо өсчихдөг. Тэр хүмүүсийнх ингээд энгийн хэвээрээ байх гээд байгаа ийм юм байна лээ. Тэгэхээр одоо таны ярьж байгаа тэр гэрээт болгох уу, цэргийн албан хаагч болгох уу энэ асуудлаа бид бас хурдхан шиг шийдэж нэг гаргалгаа хийхгүй бол тэнд ажиллаж байгаа хүмүүс яг адилхан нөхцөлд амьдарч ажиллаж байгаа. Тэгсэн хэр нь цалин нь ийм хүнд байгаад байдаг. Энгийн боловч таны хэлдэг яг үнэн л дээ. Одоо тэгээд л жагсвал жагсаад л, гүйвэл гүйгээд л тэдэн цагт бэлэн бол бэлэн бай гэдэг. Тэгэхээр энэ бол аягүй тийм ялгамжтай. Тэгээд энэ чинь цалингийн зөрүү их болчихлоо. Тийм байна лээ шүү. Тэгэхээр энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хороо ч гэсэн бас.../минут дуусав/

**П.Анужин:** Идэрбат гишүүнд баярлалаа. Санал хэллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн өргөн мэдүүлсэн Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг бид нар хэлэлцэж байна. Хуулийн төсөлтэй холбоотойгоор Байнгын хорооны гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Уг санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Даваажанцаны Сарангэрэлийг томилж байна. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

14.34 цаг.

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд орёе. Монгол Улсын Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байгаа.

Бас цөөхөн хоногийн өмнө эмийн сонсгол явагдаж, түр хороо ажиллаж, өнөөдөр бас Улсын Их Хуралд тайлангаа тайлагнасан байгаа. Эмийн асуудлуудын талаар бас маш нарийн мэдээ мэдээллүүдийн энэ талаар ард иргэд маань бас хангалттай мэдээлэлтэй байгаа. Энэ үед бас Засгийн газар маш удаан хугацаанд боловсруулсан энэ бол яаралтай гэнэт боловсруулчхаж байгаа гэсэн үг биш бас үе үеийн Засгийн газрыг дамнан бас цаг хугацаа зарцуулж ингээж боловсруулсан хууль өргөн баригдаж байна.

**Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг бид хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын гишүүн Содномын Чинзориг танилцуулна. Микрофонд урьж байна.

**С.Чинзориг:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг 1998 онд анх баталсан байдаг. Эмийн тухай хуульд 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Олон улсын стандартын шаардлага хангасан эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаанд орчин үеийн технологи болон зохистой дадлыг бүрэн нэвтрүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өргөнөөр ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт нийлүүлэлт, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэлттэй холбогдсон харилцааг цогцоор нь зохицуулах зорилгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж танилцуулж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд дараах зарчмын томоохон өөрчлөлтүүдийг оруулсан болно.

1.Эмийн чанар, аюулгүй байдал, эмийн үнийг бууруулах зохицуулалтыг нэлээн тодорхой болгож хуульчлахаар оруулж байгаа. Эмийн чанарыг хянах зорилгоор био эквивалент буюу

эмчилгээний идэвхийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд болон эмийн чанарын лабораторид хийх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Эмийн үйлдвэрүүд чанарын хяналтын итгэмжлэгдсэн лабораторитой байх талаар эмийн үйлдвэрүүдэд тавигдах шаардлагад бас тусгасан. Төрөөс зохицуулалт хийх аргуудыг хуульд нэлээн нарийвчлан тусгаж өгч байгаа. Тухайлбал бүх түвшинд эмийн үнийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон улсын чанарын шаардлага хангасан эм эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллага болон гадаад орноос худалдан авах үнийн хэлцэл хийх, үнийн дээд хязгаар нэмэгдэх хувь хэмжээг тогтоох арга зэргийг нарийвчлан тусгаж байгаа болно.

Мөн эмийн үнийг цахимаар хянах салбар дундын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох асуудлыг ч тусгасан. Уламжлалт эм, түүний түүхий эдтэй холбогдуулан үндэсний үйлдвэрийн уламжлалт эмийг эх сурвалжид үндэслэн бүртгэдэг байхаар, түүхий эдийг уламжлалт эмийн хамт цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдэн хянаж байхаар тусгаж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгааны хувьд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдийг хэт төөрөгдүүлсэн үйлчилгээг нь хэт дөвийлгөсөн байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн сурталчлахыг хязгаарлах заалт оруулж байна. Үүнтэй зэрэгцүүлэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ч гэсэн үйлчлүүлэгчдэдээ эм, эмнэлгийн хэрэгслийг сурталчлах асуудлыг хязгаарлана.

Эм ханган нийлүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг илүү өргөжүүлж олон улсын жишигийн дагуу дан ганц үйлдвэрлэлийн зохистой дадал бус хадгалалт, түгээлтийн зохистой дадал болон бусад шаардлагыг мөн дэлгэрэнгүй хуульчлахаар хуульчилж байгаа болно.

Улсын хэмжээнд эмийн зохицуулалтын чиглэлээр ажиллаж байгаа зөвлөл комиссын эрх, үүргийг илүү тодорхой болгон тэдгээрийн ажиллах журмыг сайдын тушаалаар баталдаг байсныг өөрчлөхөөр хуульд тусгаж байна. Тухайлбал Эмийн зөвлөлийн гишүүдийг олон нийтэд ил тод нээлттэй байдлаар сонгох эмийн зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах шалгуур, эмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах хугацаа зэргийг тодорхой болгохоор оруулж байгаа болно. Эмийн зохицуулалтад оролцогч талууд болох төрийн байгууллагуудын эрх, үүргийг илүү оновчтой болгохын зэрэгцээ төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэгийн холбоод эмийн төлөөллийн газрын үүрэг оролцоог мөн хуульчилж илүү тодорхой болгохоор тусгаж байгаа болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх талуудын чиг үүрэг тодорхой болж, чанар, аюулгүй байдлын зохицуулалт илүү боловсронгуй болж, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөргөдөл буурч, иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахтай холбогдсон санхүүгийн эрсдэл буурна гэж үзэж байна.

Байнгын хорооны гишүүд ээ,

Засгийн газраас яаралтай горимоор өргөн барьсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**П.Анужин:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдэд Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Намдагийн Гэрэлт-Од Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Ганхуягийн Түвшинбаяр Эрүүл мэндийн

яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ламжавын Зэндмаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна. Ахиад бас 3 гишүүн байгаа юм байна. Уучлаарай. Даваасүрэнгийн Оюун-Эрдэнэ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тогтохын Мөнхтуул Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга, Рэнцэнгийн Энхсүрэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж, үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Асуулт, үг хамт явна. Байхгүй байна.

Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ. Санал хураалт. 77,8 хувиар тус санал дэмжигдлээ.

Баярлалаа гишүүддээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг томилж байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудал өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон нийт гишүүддээ баярлалаа.

14.42 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ